



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№66 /280/ 2022.04.05

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ЁС ЗҮЙ, БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ГАРДУУЛАВ



"Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудад гардуулах ёслолын ажиллагааг өнөөдөр зохион байгуулав.

Энэхүү ёслолд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлагч, нэгтгэл, анги, байгууллагуудын захирагч, дарга нар оролцсон юм.

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудад гардуулах ёслолын ажиллагааг нээж хэлсэн үгэндээ "Эх орноо батлан хамгаалж, иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах чухал үндсэн суурь нь алба хаагчдыг ёс зүй, тэсвэр хатуужилд сургаж, зайлшгүй тулгарч болох бие бялдар, сэтгэл зүйн өндөр ачааллыг даван туулж, үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх хөтөлбөр нь алба хаагчдын ёс зүй, албаны хандлагыг дээшлүүлж, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлжилттэй, дүрэмч жансаалч, албан тушаалын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан хүний нөөцийг бүрдүүлэх үндсэн зорилготой" гэдгийг онцлов.

Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо "Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, 6 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд олон чухал асуудлыг тусгасны дотор нэгдмэл удирдлагатай Зэвсэгт хүчнийг төлөвшүүлэх, үндэсний хэмжээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үүрэг гүйцэтгэх чадавхыг улам бүр нэмэгдүүлэх зорилт бий. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийг хангах эн тэргүүний зорилт нь нийт алба хаагчдын ёс зүй, бие бялдар, сэтгэл зүйн асуудал юм. Өнөөдөр энэхүү хөтөлбөрийг Та бүхэнд хүргэж байна. Иймээс эх оронч үзэл, зөв ёс суртахуунтай, орчин үеийн шаардлагад нийцсэн, бэлтгэгдсэн чадварлаг алба хаагчийг төлөвшүүлэх зорилт

нэн тэргүүнд тавигдаж байгаа бөгөөд мөрдэстэй алба хаагч бүхэн үүрэг гүйцэтгэх чадавхтай байх, өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалах, биеийн зохистой харьцааг хангах явдал юу юунаас илүү чухал. Цаашид төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нэр хүнд, үнэлэмжийг ямагт дээшлүүлэх, алба хаагч бүр хүчирхийлэл, архидалт, элдэв хорт зуршлаас ангид байхад онцгой анхаарах ёстой"-г анхаарууллаа.

Мөн энэ үеэр Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга О.Баасан, Батлан хамгаалах аж үйлдвэрийн дэд захирал, "Зөв хандлага-Эрүүл мэнд" клубын гишүүн, бэлтгэл хурандаа Ө.Батмөнх нар үг хэлсэн бөгөөд Зэвсэгт хүчний Жанжин штабаас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдад хандаж гаргасан уриалгыг уншиж танилцуулав.

Үүний дараа Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нар төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дарга, удирдах албан тушаалтнуудад "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчийн ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг гардуулсан юм.

Мөн энэ үеэр бие бялдрын бэлтгэлжилтийн туухай өргөлтийн үзүүлэх сургуулийг сонирхуулсны дараа Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Зөв" клубын тэргүүн И.Баярсайхан нар төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагад хоёрдогч түүхий эдийг ашиглан үйлдвэрлэсэн 100 ширхэг туухайг хүлээлгэн өгч, амжилт хүслээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өндөр хариуцлага, ёс зүй, зөв хандлага, төлөвшилттэй алба хаагч бүхий төрийн алба бэхжиж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо сайжирч, бие бүрэлдэхүүний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилт хангагдан, төрийн тусгай алба хаагчдын дүрэмч, жагсаалч байдал, сахилга бат, ажлын хариуцлага сайжирч, нийгэмд эзлэх байр суурь нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	27

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,030.00	3,050.0
EUR	3,560.0	3,660.0
CNY	495.00	499.00
RUB	36.50	37.30
JPY	27.00	28.00
KRW	2.63	2.71

ЗУРХАЙ



2022.04.05 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 4/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР ХУЛГАНА ӨДӨР

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна
Наран ургах, шингэх:
06.23-19.27
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Сэрэхүй
Суудал: Үс

Энэ өдөр луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлгө тавих, морь уралдахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргалва зохистой. Ханш нээх улирал 3 цаг 27 минутад эхэлнэ. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,551 /69.9%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,174,793 /66.8%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,033,333 31,8% 115,765 /3,6%/
НИЙТ БАТЛАГДСАН 8435 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 0	ЭДГЭРСЭН 8314

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 492,846,297

Эдгэрсэн

Нийт: 428,093,439

Нас барсан

Нийт: 6,179,293

Эрүүл мэндийн газрагийн шимтгэлийг нь ТӨР ХАРИУЦАН ТӨЛӨХ ИРГЭД

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2% -иар

- Тэтгэвэрээ өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн
- Нийгмийн халамжийн гэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өргөн тусуун иргэн
- Хүүхдээ 2 дугар сар 3 нас хүртэл нь өсгөн бойжуулж халамж үзүүг
- Хугацаат цэргийн албан хаагч
- Ал эрхэлж байгаа иргэн

сая 8,400Т 0 - - - - - 100,800Т жилд

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1% -иар

- 0-18 насны хүүхэд

сая 4,200Т 0 - - - - - 50,400Т жилд

Та өөрийн ЭМД-ын шимтгэл төлөхийн мэдээлэлд байгаа газраасаа, холбаран шалгалт болон өөрийн WWW.EMD.GOV.MN

Цахим шууданд

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ ҮЗЭГЛЭВ



сэтгэл зүйн хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан нарын албаны хүмүүс оролцлоо.

ЗХЖШ, "Гэр бүлийн судалгаа боловсролын үндэсний хүрээлэн" ТББ хамтран "Иргэн-цэргийн хамтын ажиллагаа"-г хөгжүүлэх, сургалт мэдээлэл, зөвлөгөө, нөлөөллийнүйлажиллагааг хэрэгжүүлэх, гэр бүл, сэтгэл зүйн боловсролыг сурталчлан таниулах, түүгээр дэлгэрүүлэх, Зэвсэгт хүчний нэгтгэл анги, байгууллагын удирдлагын сэтгэл зүйн мэдлэг, арга зүйн сургалтыг дэмжиж, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гэр бүл, сэтгэл зүйн хэрэгцээ, онцлогийг тодорхойлох, судалгаа явуулах зэрэг ажлуудыг цаашид хамтарч хэрэгжүүлэх юм.

ЗХЖШ, "Гэр бүлийн судалгаа боловсролын үндэсний хүрээлэн" ТББ-тай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.

Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Сургалт бэлтгэлийн газрын

дарга бригадын генерал Г.Болор, "Гэр бүлийн судалгаа боловсролын үндэсний хүрээлэн" ТББ-ын захирал доктор Б.Оюун-Эрдэнэ, сургагч багш Б.Азжаргал, ЗХЖШ-ын сургалт бэлтгэлийн газрын суртал хүмүүжил,

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ "АХЛАГЧИЙН АЛБЫГ ХӨГЖҮҮЛЭХ-2024" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Тус нэгтгэл ахлагчийн хөгжлийн төвийг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хуурай замын цэргийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар, Хуурай замын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр, Хуурай замын цэргийн командлагч цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн дарга хурандаа Т.Тогмиддүүмий нар тус хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцаж

цаашид сургалт бэлтгэлийг явуулах орчин нөхцлийг сайтар бүрдүүлж ажиллах талаар үүрэг чиглэл өглөө. Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 101 жилийн ой, Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн 100 жилийн ойг тохиолдуулан нэгтгэлийн ахлагчийн зөвлөлөөс санаачлан "Өөрийгөө хөгжүүлэх төв"-ийг шинээр байгуулан нээлтээ хийлээ.

Тус төвийн үйл ажиллагааг эхлүүлснээр офицер, ахлагч нарын гадаад

хэл, компьютерийн мэдлэгийг дээшлүүлэх, цэргийн алба хаагч бүр бие даан хууль, эрх зүйн мэдлэгийг цахим хичээлээр судлах бүрэн боломжтой болох юм. Цаашид тус өөрийгөө хөгжүүлэх төвөөр дамжуулан нэгтгэлийн офицер, ахлагч, ажилтан албан хаагч нар үйлчлүүлэн өөрсдийнхөө мэдлэг, боловсролыг дээшлүүлэх нөхцөл бололцоо бүрдсэн юм.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

ОЛОН ТӨРЛИЙН ТЭМЦЭЭН УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 104 дүгээр тусгай ротын бүрэлдэхүүн Өмнөговь аймгийн Номгон суманд Зэвсэгт хүчний сурталчлах Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд албан байгууллага, ард иргэдийн дунд "Гар бөмбөг"-ийн тэмцээн, "Хөгжөөнт буухиа" тэмцээн, үндэсний спортыг дэмжих, монгол уламжлалаа түүгээр дэлгэрүүлэх зорилгоор хүчит бөхийн барилдаан, шагайн харвааны тэмцээнийг амжилттай зохион байгуулж явууллаа.

"Гар бөмбөг"-ийн тэмцээнд нийт 16 багийн 96 тамирчид

оролцож нэгдсэн дүнгээр Б.Отгонбаяр ахлагчтай баг хамт олон тэргүүн байранд шалгарсан бол дэд байранд О.Батзориг ахлагчтай баг, гутгаар байранд Д.Ганболд ахлагчтай баг хамт шалгарлаа. "Хөгжөөнт буухиа" тэмцээнд 7 багийн 35 тамирчин оролцож, Х.Мөнхбат ахлагчтай баг



тэргүүн байранд шалгарсан бол дэд байранд Х.Энхцэцэг ахлагчтай баг, гутгаар байранд Н.Жаргалсүрэн ахлагчтай баг тамирчид хурд хүч авхаалж самбаа гарган бусдыгаа хошуучиллаа.

Тус зохион байгуулсан тэмцээн уралдаан нь Өмнөговь аймгийн Номгон суманд үйл ажиллагаа явуулдаг байгууллага хамт олон гэхээсээ илүүтэй ард иргэд рүү чиглэсэн үйл ажиллагаа тул тэмцээнд оролцож баг тамирчид гэр бүл найз нөхдийн хүрээлээр баг бүрдүүлж тэмцээнд оролцсон юм.

С.Ганбямба: ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫНХАА БОЛОН АР ГЭРТ НЬ ТУЛГАРЧ БУЙ АСУУДАЛД ДЭМ БОЛЖ АЖИЛЛААРАЙ

Зэвсэгт хүчинд нэн шаардлагатай байгаа чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын санаачилсан "Хүний хөгжлийн менежер", "Цэргийн сэтгэл зүйч"-ийг бэлтгэх мэргэшүүлэх сургалтад суралцаж төгссөн алба хаагчдыг ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал С.Ганбямба хүлээн авч, үүрэг чиглэл өглөө.

Тэрээр "Юуны өмнө та бүхэнд цэргийн алба хаагч болох энэхүү замыг сонгосон явдалд баяр хүргэе. Энэ сонголтыг хийх боломжийг бүрдүүлсэн ар гэрийнхэнд мөн талархал илэрхийлж байна. Цэргийн алба гэдэг сайхан алба. Та бүхэн удахгүй хуваарьт ангидаа очоод цэргийн албаны жаргал зовлонг мэдрэх болно. Мөн шинээр очиж байгаа учир бүх зүйлийг соргоогоор хүлээн авч, өөрсдийн хэмжээнд шинэчлэх боломжийг бүрдүүлж чадна. Тиймээс анхнаасаа, очсон өдрөөсөө бүтээлч байж, бүх зүйл эрэлхийлж албандаа дадаарай. Шинээр томилогдож байгаа сэтгэл зүйчдийн дийлэнх нь хугацаат ангид томилогдож байгаа. Тиймээс та бүхэн аав ээжийн гараас цэргийн албанд ирж байгаа байлдагчдад ямар сэтгэгдэл төрүүлж албанд нь дасгах, цаашид хэрхэн алба хаах гээд бүхий л зүйл оролцоотой байхаас гадна асуудалтай байгаа хэн нэгэнд чин сэтгэлээсээ тусалж ойрын зөвлөх нь байж, асуудлыг даван туулах хамтрагч нь байж өгөөрэй.

Түүнчлэн ангийн байнгын бүрэлдэхүүн, энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй алба хаагч тэдний ар гэрт тулгарч



байгаа асуудалд дэм болж ажиллаарай. Гэр бүлийн харилцаа, итгэлцэл зэргийг талаар танилцуулга сургалтуудад хамруулахаа гадна нийгмийн гажуудал болж буй гэр бүлийн гадуурх харилцааны талаар ч мөн зохих сургалтыг явуулах хэрэгтэй.

Энэ мэт та бүхний хийх ажил их байгаагийн дээр хүлээсэн үүрэг чухал бөгөөд хариуцлагатайг энд дахин хэлье. Ингээд та бүхний ажилд амжилт хүсье" гэв.

хүртэлх хугацаанд ҮБХИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийг түшиглэн "Цэргийн сэтгэл зүйч" бэлтгэх мэргэшүүлэх сургалтад иргэний боловсролын их, дээд сургуулийг сэтгэл судлал, сэтгэл зүйч мэргэжлээр төгссөн цаашид цэргийн сэтгэлзүйн чиглэлээр ажиллах хүсэл сонирхолтой суралцагсдын хамруулсан бол "Хүний хөгжлийн менежер"-ийн сургалтад Зэвсэгт хүчинд офицер, ахлагчийн албан тушаалд



Үргэлжлүүлээд ЗХЖШ-ын сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор болон Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хэлтсийн дарга хурандаа Ц.Батсайхан нар дээрх алба хаагчдад чиглэсэн үүрэг өгч шинэ албанд нь амжилт хүссэн юм. Ташрамд дурдахад 2021 оны 12 дугаар сарын 3-наас өнгөрсөн сарын сарын 10-н

ажилладаг, бакалаврын зэрэгтэй, дипломын голч дүн 2,7-оос доошгүй, мөн цаашид энэ чиглэлээр ажиллах хүсэл, сонирхолтой залуусыг тус тус шалгаруулан тус сургалтад хамруулсан юм. Тэд ийнхүү сургалтаа амжилттай хамрагдаж төгсөөд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт томилогдоод дарга нараасаа үүргээ аван шинэ албандаа мордлоо.

ФРАНЦ ДУУНЫ ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО




Жил бүрийн 3 дугаар сарын сүүлээр Олон улсын франц хэлтнүүдийн өдрийг дэлхийн олон оронд тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд энэ арга хэмжээний хүрээнд соёл урлагийн олон үйл ажиллагаа зохион явуулдаг билээ. Уг наадмыг Улаанбаатар дахь Франц-Монголын нийгэмлэг, Монгол дахь франц хэлний багш нарын холбоо, МУИС, ҮБХИС гэх мэт олон байгууллагууд хамтран зохион байгуулдаг уламжлал болсон арга хэмжээ юм. Тус арга хэмжээний үеэр дуу, яруу найраг, эсээ бичлэг, цээж бичиг, фото зургийн гэх мэт олон уралдаан тэмцээн болдог бөгөөд франц хэл сургадаг их дээд сургуулиуд өөрсдийгөө

таниулах сурталчлах нэг том боломж гэж үздэг чухал наадам юм. Энэ жилийн 23 дахь удаагийн наадамд ҮБХИС-ийн ГХСТ-ийн франц хэлний бэлтгэл дунд шатанд суралцагч Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ахлах дэслэгч Б.Түмэн-Өлзий, Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн ахлах ахлагч Б.Нямбаяр оролцон франц дууны тэмцээний эцсийн шалгаруулалтад амжилттай тэнцэн оролцлоо.

Ахлах дэслэгч Б.Түмэн-Өлзий тус тэмцээнд "Je danse encoeur" дуугаар оролцон 2 дугаар байр эзэлсэн сайхан амжилтыг үзүүлсэн юм.

Ташрамд дурдахад энэхүү уралдаанд өмнөх жилүүдэд ҮБХИС-ийн ГХСТ-



ийн франц хэлний суралцагсад амжилттай оролцож ирсэн юм. Тухайлбал 2012 онд ахлах дэслэгч Н.Насанбат дууны төрөлд тэргүүн байр, 2014 онд ахлах дэслэгч Н.Наранцогт яруу найргийн төрөлд тусгай байр, 2015 онд ахлах дэслэгч Х.Үүрийнтуяа цээж бичгээр мөн тусгай байранд тус тус шалгарч байв. ҮБХИС-ийн франц хэлний дамжаанд суралцагчдын хувьд их дээд сургуулийн франц хэлний 3 ба 4 дүгээр курсийн оюутнуудтай шалгаруулалтад оролцдог тул маш өрсөлдөөнтэй их хичээл зүтгэл шаардсан, мөн өөрсдийгөө сорих нээх болон сургууль хамт олноо сурталчилсан чухал үйл явдал байдаг билээ.